



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/13

Хэрлэн сум

Комисс шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн өмчит байгууллагуудын эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Хөтлөгч:	С.Хэрлэнчимэг	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Тэмдэглэл хөтлөгч:	О.Баяртөгс	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Хоёр. Бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2016 оны "Дуудлага худалдаа зохион байгуулах тухай" А/427 дугаар захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүйд тооцсугай.

Гурав. Нээлттэй дуудлага худалдааг хуулийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА